



Өвөрхангай аймгийн Засаг даргын дэргэдэх  
Статистикийн хэлтэс

# ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ-2016



Арвайхээр хот  
2017 он

## Агуулга

❖ Судалгааны зорилго	
❖ Судалгааны агуулга.....	2
1. Хүн амын тоо, нас, хүйсийн бүтэц.....	3
1.1 Суурин хүн амын тоо,Хөдөлмөрийн насны хүн ам /насны бүтэц, сумаар/	
1.2 Хүн ам зүйн зарим үзүүлэлтүүд	
2. Хөдөлмөрийн зах зээлийн үзүүлэлтүүд.....	5
2.1 Хүн амын ажил эрхлэлт, мянган хүнээр	
2.2 Ажиллах хүчний зах зээл, ажилгүйдлийн түвшин	
2.3 Хангайн бүсийн амгуудын хөдөлмөр эрхлэлт	
3.Ажиллагсад.....	7
3.1 Ажиллагсдын тоо, эдийн засгийн салбарын ангиллаар	
3.1 Ажиллагсдын тоо, насны бүлгээр	
3.2 Аймгийн албан бус сектор дахь ажиллагсдын тоо, хүйс, насны бүлэг, байршлаар, 2015 оны байдлаар	
4.Ажилгүйчүүд.....	9
4.1 Хангайн бүсийн аймгуудын ажилгүйдлийн үзүүлэлтүүд	
4.2 Ажилгүйдлийн түвшин	
5. Эдийн засгийн идэвхгүй хүн ам.....	11
5.1 Эдийн засгийн идэвхгүй хүн ам, шалтгаанаар	
Дүгнэлт.....	13
Ашигласан материал, номзүй.....	14
Хүн амын хөдөлмөр эрхлэлтийн бүтэц.....	15

## Судалгааны агуулга, зорилго

Хөдөлмөр эрхлэлтийн талаарх аймгийн мэдээ, мэдээлэл, статистик тоо баримтуудыг ашиглаж, өнөөгийн хөдөлмөр эрхлэлтийн байдал ямар түвшинд байгааг судлах, аймгийн хүн амын ажил эрхлэлт, ажилгүйдлийг нас хүйстэй нь уялдуулан судалж ажил эрхлэлтийг эдийн засгийн салбарын ангилалаар харуулан, хүн ам зүйн ачаалал, ажил эрхлэлт, ажилгүйдлийн түвшин зэрэг үзүүлэлийг тодорхойлон харуулахыг зорьлоо.

### Хамрах хүрээ

Ажиллах хүчний судалгаагаар хүн амын хөдөлмөр эрхлэлтийн талаарх бодит тоон мэдээллийг улсын хэмжээнд болон бүс нутаг, аймгийн түвшинд тооцож тодорхойлно.

### Мэдээлэл цуглуулалт

Судалгааны асуулга нь 8 бүлэг, 142 асуултаас бүрдэж байгаа бөгөөд судлаач сонгогдсон өрхөд очиж 15, ба түүнээс дээш насны гишүүн бүртэй нэг бүрчлэн уулзаж, ярилцлага хийх замаар мэдээллээ цуглуусан.

### Мэдээлэл боловсруулалт

Өрхөөс ярилцлага авч, цуглуулсан мэдээллийг зааврын дагуу шалгаж, кодлон компьютерт програмп шивэн оруулах, шалгах, засвар хийсний дараа төвд дамжуулах ажлыг аймгийн хэмжээнд статистикийн хэлтсийн ажиллах хүчний судалгаа хариуцсан ахлагч, ахлах мэргэжилтэн нар хийж гүйцэтгэсэн.

АХС-ны мэдээллийг компьютерт шивж оруулах, шалгах, засварлахад тооллого, судалгааны мэдээлэл боловсруулдаг CSPRO 5.0 багц програмыг, бэлэн болсон мэдээллийн үр дүнг боловсруулж, холбогдох хүснэгтүүдийг SPSS13.0 програмыг тус тус ашиглан улмаар статистикийн дүн шинжилгээ хийж, судалгааны боловсруулалтын үр дүнг хянах, илэрсэн алдааг засварласны үндсэн дээр судалгааны үр дүнгийн хүснэгтүүдийг боловсруулсан.

**I.Хүн амын тоо, нас, хүйсийн бүтэц**

Улс, аймгийн эдийн засгийн хөгжил иргэдийнх нь аж байдал, амьжиргааны ерөнхий түвшин нь хүн амынхаа ажил эрхлэлтийн түвшинтэй зохих ёсоор холбоотой байдаг. Ажиллах хүч, ажил эрхлэлтийн байдал нь хүн амын насны бүтцээс шууд хамааралтай байдаг учраас аймгийн хүн амын нас, хүйсийн бүтцийг авч үзье.

2016 оны жилийн эцэст аймгийн хүн ам 113.9 мянгад хүрсний 50.2 хувийг эмэгтэйчүүд эзэлж байна.

**Хүснэгт 1. Суурин хүн амын тоо,Хөдөлмөрийн насны хүн ам/насны бүтэц, сумаар/2016он**

Сумын нэр	Бүгд	Эм	0-14		15-59		60+		Хөдөлмөрийн насны хүн ам
			Эм	Эм	Эм	Эм			
Баян-Өндөр	3810	1908	1134	562	2357	1161	319	185	2357
Бүрд	2906	1417	837	421	1823	862	246	134	1823
Бат-Өлзий	7372	3713	2387	1203	4637	2318	348	192	4637
Баруунбаян-Улаан	2773	1387	885	428	1735	871	153	88	1735
Баянгол	3879	1922	1095	536	2542	1236	242	150	2542
Гучин-Ус	2187	1103	655	326	1407	703	125	74	1407
Есөнзүйл	3074	1511	925	452	1913	923	236	136	1913
Өлзийт	2431	1195	725	355	1481	720	225	120	1481
Зүүнбаян-Улаан	4026	1974	1205	602	2567	1232	254	140	2567
Богд	5548	2738	1833	854	3462	1740	253	144	3462
Нарийнтээл	3565	1773	988	490	2370	1170	207	113	2370
Сант	3569	1758	1046	491	2288	1134	235	133	2288
Тарагт	3323	1613	954	476	2129	1003	240	134	2129
Төгрөг	2735	1355	822	388	1748	867	165	100	1748
Уянга	9485	4758	2979	1446	6042	3015	464	297	6042
Хайрхандулаан	3470	1695	990	473	2235	1086	245	136	2235
Хужирт	6660	3288	1992	961	4102	2005	566	322	4102
Хархорин	12405	6193	3404	1657	7937	3931	1064	605	7937
Арвайхээр	30693	15897	9186	4508	19458	10142	2049	1247	19458
<b>Бүгд</b>	<b>113911</b>	<b>57198</b>	<b>34042</b>	<b>16629</b>	<b>72233</b>	<b>36092</b>	<b>7636</b>	<b>4450</b>	<b>72233</b>

Аймгийн нийт хүн амын 26.9 хувь нь Арвайхээр, 10.9 хувь нь Хархорин, 8.3 хувь нь Уянга, 5.8 хувь нь Хужирт суманд, хамгийн бага 2.4 хувь нь Төгрөг, 2.1 хувь нь Өлзийт, 1.9 хувь нь Гучин ус сумдад амьдарч байна. Нийт хүн амын 29.9 хувийг 0-14 насныхан, 63.4 хувийг 15-59 насныхан, 6.7 хувийг 60 ба түүнээс дээш насныхан байна. Өнгөрсөн оноос 0-14 насны хүн амын эзлэх хувийн жин 0.4 пунктээр өсч, 60 ба түүнээс дээш насны хүн ам 0.1 пунктээр нэмэгдэж, 15-59 насны хүн ам 0.5 пунктээр буурчээ.

**Хүснэгт 2. Хүн ам зүйн зарим үзүүлэлтүүд**

Он	Өрхийн тоо	Хүн амын тоо	Жилийн дундаж өсөлт	Нэг өрхөд ногдох хүний тоо	Хүйсийн харьцаа	Хүн ам зүйн ачаалал
<b>2012</b>	32072	110541	1.5	3.44	99.6	53.9
<b>2013</b>	32421	111824	1.2	3.44	98.9	54.5
<b>2014</b>	33015	112591	0.7	3.41	99.1	55.3
<b>2015</b>	33275	112774	0.2	3.39	99.3	51.4
<b>2016</b>	33540	113911	1.0	3.40	99.2	52.0

Аймгийн нэг өрхөд 3.4 хүн ногдож, хүн амын хүйсийн харьцаа 99.2, хүн ам зүйн ачаалал 52.40 байна. Өнгөрсөн оноос нэг өрхөд ногдох хүний тоо 0.01-пунктаар, хүн ам зүйн ачаалал 0.6–пунктаар өсч, хүйсийн харьцаа 0.1-пунктаар буурсан байна.

**II. Хөдөлмөрийн зах зээлийн үзүүлэлтүүд**

2008 оноос Ажиллах хүчний түүвэр судалгааны үр дүнгээр хөдөлмөрийн статистикийн үзүүлэлтүүдийг үндэсний хэмжээнд болон аймаг, бүсээр тооцон гаргаж байна. Энэхүү судалгаа нь олон улсад мөрдөж буй нийтлэг тодорхойлолт, арга зүйн дагуу хүн амын эдийн засгийн идэвхийг сүүлийн 7 хоног буюу тухайн үеийн, сүүлийн 12 сарын буюу байнгын идэвхийн аргачлалаар тооцох замаар хүн амын хөдөлмөр эрхлэлтийн байдлыг тодорхойлдог.

Уг судалгаагаар тус аймагт эдийн засгийн идэвхтэй 54.4 мянган хүн байгаагийн 91.1 хувь буюу 49.6 мянга нь ажиллагсад, 8.8 хувь буюу 4.8 мянган хүн нь ажил хайж байгаа хүмүүс байна.

**Хүснэгт 3. Хүн амын ажил эрхлэлт, мянган хүнээр**

	2012	2013	2014	2015	2016
Эдийн засгийн идэвхтэй хүн ам	54.3	57.7	54.4	53.4	54.4
Ажиллагчдын тоо	52.4	54.8	52.5	51.4	49.6
Ажилгүй иргэдийн тоо	1.8	2.9	1.9	1.9	4.8
Ажилгүйдлийн түвшин ( % )	3.4	5.0	3.5	3.6	8.9
Эдийн засгийн идэвхгүй хүн ам	17.6	16.9	17.8	19.8	17.7

Өмнөх оноос ажиллагсдын тоо 3.5 хувиар буурч, ажил хайж багаа иргэдийн тоо 2.5 дахин өсч, ажилгүйдлийн түвшин 5.3 пунктээр тус тус өсчээ. Эдийн засгийн идэвхгүй хүн амын тоо 10.6 хувиар буюу 2.1 мянган хүнээр нэмэгдсэн байна. Ажиллагсадын тоо 2016 онд 2014 оныхоос 5.5 хувиар буюу 2.9 мянган хүнээр, 2015 оныхоос 3.5 хувиар буюу 1.8 мянган хүнээр тус тус буурчээ.

Ажиллах хүчний оролцооны түвшин нь хөдөлмөрийн зах зээлийн хөгжил, хүн амын эдийн засгийн идэвхийн байдлыг харуулдаг. Мөн хөдөлмөрийн насны хүн амын хөдөлмөр эрхлэлтийн байдал, эдийн засагт хөдөлмөрийн насны хүн амыг ажлын байраар хангах зорилтын хэрэгжилтийг хянах хэмжүүр болдог. Ажиллагчид болон ажил идэвхтэй эрж хайж байгаа ажилгүй иргэдийн нийлбэр нь эдийн засгийн идэвхтэй хүн ам буюу ажиллах хүчийг бүрдүүлдэг бөгөөд эдгээр хүн амыг хөдөлмөрийн насны хүн амд харьцуулж ажиллах хүчний оролцооны түвшин (АХОТ)-г тодорхойлдог.

#### Хүснэгт 4. Ажиллах хүчний зах зээл


	2013	2014	2015	2016
Ажиллах хүчний оролцооны түвшин	79.8	75.3	72.9	75.5
Хөдөлмөр эрхлэлтийн түвшин	75.7	72.7	70.3	68.8
Ажилгүйдлийн түвшин	5.0	3.5	3.6	8.9

Аймгийн АХОТ нь 2016 онд 75.5 өөрөөр хэлбэл хөдөлмөрийн насны 100 хүн тутмын 75 нь эдийн засгийн идэвхтэй хүн ам байна. Энэ нь өмнөх оноос 2.6 пунктээр өссөн нь хөдөлмөрийн насны хүн амын дотор эдийн засгийн идэвхтэй хүн ам бага зэрэг өссөнийг харуулж байна. Гэхдээ АХОТ нь улсын дунджаас 15.0 пунктээр дээгүүр, хангайн бүсийнхээс 4.9 пунктээр дээгүүр байна.

*Хөдөлмөр эрхлэлтийн түвшин* нь эдийн засгийн идэвхтэй хүн амын хэдэн хувийг ажил эрхэлж байгаа хүмүүс бүрдүүлж байгааг харуулдаг үзүүлэлт юм. Энэ үзүүлэлт манай аймгийн хувьд 2014 онд 72.7 байсан ба 2015 онд 70.3 болж, 2.4 пунктээр, 2016 онд 68.8 болж өмнөх оноос 1.5 пунктээр тус тус буурчээ.

*Ажилгүйдлийн түвшинг* ажилгүй иргэдийн тоог эдийн засгийн идэвхтэй хүн амд харьцуулж тооцдог.

#### Зураг 1. Ажилгүйдлийн түвшин



Судалгааны дүнгээр ажил эрхлээгүй нийт хүн амаар тооцсон ажилгүйдлийн түвшин аймгийн хэмжээнд 2016 онд 8.9 хувьд хүрч өмнөх оноос 5.3 пунктээр өсчээ.

**Хүснэгт 5. Хангайн бүсийн аймгуудын хөдөлмөр эрхлэлт**

Хангайн бүсийн аймгууд	Ажиллагсадын тоо(мян хүн)					Эдийн засгийн идэвхтэй хүн (мян хүн)				
	2012	2013	2014	2015	2016	2012	2013	2014	2015	2016
Архангай	48.0	46.2	43.6	40.2	42.4	49.6	48.3	45.3	42.3	44.6
Баянхонгор	37.3	36.3	37.8	39.0	40.0	38.6	39.1	40.0	41.7	45.0
Булган	26.9	27.5	25.3	27.0	25.8	29.6	28.9	28.1	28.3	28.1
Орхон	35.7	31.1	35.4	38.3	33.1	41.7	39.4	40.3	39.1	42.7
Өвөрхангай	52.4	54.8	52.5	51.4	49.6	54.3	57.7	54.4	53.4	54.4
Хөвсгөл	50.8	53.5	48.5	52.7	54.6	59.9	63.0	52.7	56.5	59.6
Хангайн бүсийн дүн	251.1	249.4	243.1	248.6	246.6	273.7	276.4	260.8	261.3	215.2
Улсад	1056.4	1103.6	1110.7	1151.2	1147.8	1151.1	1198.3	1206.6	1243.9	1275.6

Хангайн бүсийн аймгуудын ажиллагсадын тоог зэрэгцүүлж харахад хамгийн их нь Хөвсгөл аймаг 54.6 мянган ажиллагсадтай хамгийн бага нь 25.8 мянган ажиллагсадтай Булган аймаг байна. Ажиллагсадын тоогоор манай аймаг хангайн бүсийн дүнд 20.1 хувийг, улсын дүнд 4.3 хувийг эзэлж байна.

### III. Ажиллагсад

Ажиллах хүчний судалгаа нь хүн амын хөдөлмөр эрхлэлтийн байдлын талаар дэлгэрэнгүй мэдээллийг цуглуулах зорилготой билээ.

Судалгааны үр дүнгээр 2016 онд 49.6 мянган хүн ажил эрхэлж байгаа ба энэ нь өмнөх оноос 3.5 хувиар буюу 1.8 мянган хүнээр буурсан байна. Аймгийн ажиллагсдын 47.0 хувь нь эмэгтэйчүүд байгаа нь өмнөх оноос 1.6 пунктээр өсчээ.

#### Хүснэгт 6. Ажиллагсдын тоо, эдийн засгийн салбарын ангиллаар

Эдийн засгийн салбарууд	2014	2015	2016	2016
				2011
Хөдөө аж ахуй, ан агнуур, ойн аж ахуй	30297	29829	29319	98.3
Уул уурхай	1386	1704	1568	92.0
Боловсруулах үйлдвэр	2468	1510	3087	204.4
Барилга	1382	1808	1144	63.3
Цахилгаан, хий үйлдвэрлэл, усан хангамж	1270	224	347	154.9
Бөөний болон жижиглэн худалдаа	5118	5295	4324	81.7
Зочид буудал зоогийн газар	608	886	843	95.1
Тээвэр, агуулах, холбоо	1754	1797	1877	104.5
Санхүүгийн гүйлгээ хийх	232	593	350	59.0
Үл хөдлөх хөрөнгө, түрээс, бизнесийн	152	71	71	100.0
Төрийн удирдлага батлан хамгаалах	1248	1507	1763	117.0
Боловсрол	3144	3260	2924	89.7
Эрүүл мэнд, нийгмийн халамж	1479	1140	1200	105.3
Нийгэм бие хүнд үзүүлэх үйлчилгээ	1699	1408	622	44.2
Бусад	301	383	144	37.6
ДҮН	52538	51415	49583	96.4

Нийт ажиллагсадын тоо 59.0 хувийг хөдөө аж ахуйн салбарт ажиллагсад, 3.0 хувийг уул уурхай, 6.0 хувийг боловсруулах салбарын ажиллагсад, 2.2 хувийг барилгын салбарт ажиллагсад, 0.6 хувийг цахилгаан, дулааны эрчим хүчний салбарын ажиллагсад, 8.7 хувийг бөөний болон жижиглэнгийн худалдаа эрхлэгчид, 1.6 хувийг зочид буудал, зоогийн газрын ажиллагсад, 3.6 хувийг тээвэр, холбооны салбарын ажиллагсад, 3.4 хувийг төрийн удирдлага, батлан хамгаалахын салбарт ажиллагсад, 5.8 хувийг боловсролынх, 2.4 хувийг эрүүл мэндийн салбарын ажиллагсад, 0.2 хувийг бусад салбарын ажиллагсад тус тус эзэлж байна



## Хүснэгт 7. Ажиллагсдын тоо, насны бүлгээр

Үзүүлэлт	2015			2016		
	Бүгд	Үүнээс		Бүгд	Үүнээс	
		Эрэгтэй	Эмэгтэй		Эрэгтэй	Эмэгтэй
Ажиллагсад	51415	26409	25006	49583	26256	23327
15-19	2021	1433	588	1487	950	537
20-24	3980	1999	1981	2986	1907	1079
25-29	5889	3702	2187	8238	4113	4125
30-34	6300	3114	3186	7491	3968	3523
35-39	7822	3385	4436	7579	3552	4027
40-44	6868	3685	3183	6284	3620	2665
45-49	6725	3412	3313	5161	2588	2573
50-54	5353	2619	2734	4980	2780	2200
55-59	3576	1850	1727	2885	1488	1397
60+	2881	1210	1671	2494	1292	1202

Насны хувьд ажиллагсдын 15.1 хувь нь 35-39 насны, 12.5 хувь нь 40-44 насны, 10.2 хувь нь 45-49 насны, 14.9 хувь нь 30-34 насны, 16.5 хувь нь 25-29 насны, 10.0 хувь нь 50-54 насны, 6.0 хувь нь 20-24 насны, 2.8 хувь нь 15-19 насны, 5.8 хувь нь 55-59 насны, 5.0 хувь нь 60-аас дээш насны хүн ам байна.

## Хүснэгт 8: Аймгийн албан бус сектор дахь ажиллагсдын тоо, хүйс, насны бүлэг, байршлаар, 2016 оны байдлаар

Бүгд	Үндсэн	Давхар		Үндсэн	Давхар		Үндсэн	Давхар	Хот	Хөдөө
	5542	282		3221	137		2321	145		
25-29	831		Эрэгтэй	416		Эмэгтэй	415		2899	2643
30-34	756	72		409			347	72		
35-39	638	145		361	72		277	72		
40-44	1503			996			508			
45-49	703	65		414	65		289			
50-54	758			553			204			
55-59	216			-			216			
60-64	136			71			65			

Албан бус сектор дахь ажиллагчдын үндсэн болон давхар хөдөлмөр эрхлэлтийн байдлыг насаар нь авч үзэхэд 40-44 насныхан үндсэн ажлаараа албан бус хөдөлмөр эрхлэгчид хамгийн өндөр буюу 27.1 хувийг эзэлж байгаа бол эрэгтэйчүүд мөн 40-44 насныхан хамгийн өндөр 30.9 хувь, эмэгтэйчүүдийн хувьд мөн л 40-44 насныхан 21.9 хувийг эзэлж байгаа нь хамгийн өндөр байна.

#### IV. Ажилгүйчүүд


##### Хүснэгт 9. Хангайн бүсийн аймгуудын ажилгүйдлийн үзүүлэлтүүд

Хангайн бүсийн аймгууд	Ажилгүйдлийн түвшин					Ажилгүйчүүдийн тоо /мян.хүн/				
	2012	2013	2014	2015	2016	2012	2013	2014	2015	2016
Архангай	3.3	4.4	3.9	5.0	5.0	1.6	2.1	1.8	2.1	2.2
Баянхонгор	3.6	7.3	5.6	6.4	11.2	1.4	2.9	2.2	2.7	5.0
Булган	9.1	4.7	9.7	4.6	8.2	2.7	1.4	2.7	1.3	2.3
Орхон	14.2	21.1	12.3	2.2	22.4	5.9	8.3	4.9	0.9	9.5
Өвөрхангай	3.4	5.0	3.5	3.6	8.9	1.9	2.9	1.9	1.9	4.8
Хөвсгөл	15.2	15.1	7.9	6.7	8.5	9.1	9.5	4.2	3.8	5.0
Хангайн бүс	8.3	9.8	6.8	4.9	10.6	22.6	27.1	17.7	12.7	29.0
Улсад	8.2	7.9	7.9	7.5	10.0	94.7	94.7	95.8	92.7	127.8

Ажилгүйдлийн түвшин манай аймагт 8.9 хувь, Орхон аймагт хамгийн өндөр буюу 22.4 хувь байна. Манай аймгийн хувьд хангайн бүсийн түвшнээс 1.7, улсынхаас 1.1 пунктээр доогуур байна.

2016 онд аймгийн хэмжээгээр ажилгүйчүүдийн тоо өмнөх оныхоос 2.5 хувиар өссөн байна. Хангайн бүсийн аймгуудтай харьцуулахад Архангай, Булган аймгуудын дараа орж, хангайн бүсийн ажилгүй иргэдийн 16.5 хувийг, улсын хэмжээний нийт ажилгүйчүүдийн 3.7 хувийг эзэлж байна.

**Зураг 2. Ажилгүйдлийн түвшин**



**V. Эдийн засгийн идэвхгүй хүн ам**


Эдийн засгийн идэвхгүй хүн ам 17.7 мянгад хүрсэн нь өнгөрсөн оноос 10.7 хувиар буюу 2128 хүнээр буурсан байна.

Нийт эдийн засгийн идэвхгүй хүн амын 59.0 хувь нь эмэгтэйчүүд, 30.6 хувь нь 15-19 насны, 17.7 хувь нь 50-59 насны, 10.2 хувь нь 20-29 насны, 7.7 хувь нь 40-49 насны 7.2 хувь нь 30-39 насны хүн ам байна.

**Хүснэгт 10. Эдийн засгийн идэвхгүй хүн ам, шалтгаанаар**

Үзүүлэлт	2015			2016		
	Бүгд	Үүнээс		Бүгд	Үүнээс	
		Эрэгтэй	Эмэгтэй		Эрэгтэй	Эмэгтэй
<b>Дүн</b>	19815	8827	10989	17687	7257	10430
Гэрийн ажилтай	1430	225	1204	1770	277	1493
Суралцдаг	5537	3364	2173	5531	2532	2999
Тэтгэвэрт	6639	2448	4190	5154	1919	3236
Өндөр настан	393	-	393	872	143	729
Хөгжлийн бэрхшээлтэй	1518	981	538	1106	978	128
Ажил хийхийг хүсээгүй	832	302	530	275	208	67
Хүүхэд асарсан	1041	-	1041	1352	211	1141
Өвчтэй байсан	384	152	232	407	205	201
Өвчтөн, өндөр настан асарсан	154	-	154	218	-	218
Бусад	1887	1355	532	938	720	218

**Зураг 3. Эдийн засгийн идэвхгүй хүн ам, шалтгаанаар**



Нийт эдийн засгийн идэвхгүй хүн амын 31.3 хувь нь суралцдаг, 4.9 хувь өндөр настан, 6.3 хувь нь хөгжлийн бэрхшээлтэй, 1.2 хувь нь хүүхэд, өндөр настан, өвчтэй хүн асардаг, 10.0 хувь нь гэрийн ажилтай, 1.6 хувь нь ажил хийхийг хүсдэггүй, 5.3 хувь нь бусад гэсэн шалтгаантай байна.

## ДҮГНЭЛТ

Хөдөлмөр эрхлэлтийн үзүүлэлтүүд нь хүн амын насны бүтэц, боловсролын байдлаас шууд хамаардаг бөгөөд хүн амын амжиргааны түвшин, төрөлт, гэрлэлт, шилжих хөдөлгөөн зэрэг хүн амын үзүүлэлтүүдэд тодорхой нөлөө үзүүлдэг байна.

Ажиллах хүчний судалгааны үр дүнгээр 2016 онд манай аймагт 49.6 мянган хүн ажил эрхэлж байгаа ба энэ нь өмнөх оноос 3.5 хувиар буюу 1.8 мянган хүнээр буурсан байна. Ажиллагсдын 53.0 хувь нь эрэгтэйчүүд, 47.0 хувь нь эмэгтэйчүүд байна.

2016 онд ажилгүйдлийн түвшин 8.9 болж өмнөх оныхоос 5.3 пунктээр өссөн дүнтэй байна. Энэ нь эдийн засгийн идэвхтэй хүн амын 8.9 хувь нь ажилгүй байгааг харуулж байна. Мөн бүсийн хэмжээнд харьцуулахад Орхон аймаг ажилгүйдлийн түвшин хамгийн өндөр буюу 22.4, Баянхонгор аймгаас хоёрдугаарт буюу 11.2, Архангай аймаг 5.0, Булган аймаг 8.2, Хөвсгөл аймгаас 8.5 байна.

2016 оны эцэст ажил эрхлээгүй 4815 хүн байгаагийн 20.4 хувь нь 15-24 насны, 37.7 хувь нь 25-34 насны, 19.0 хувь нь 35-44 насны, 23.0 хувь нь 45-аас дээш насны ажилгүйчүүд байна.

Ажиллагчдын ихэнх нь хөдөө аж ахуйн тэр тусмаа мал аж ахуйн салбарт ажиллаж байгаа нь эдийн засгийн бусад дэд салбарыг хөгжүүлэх, аж үйлдвэр тэр дотроо боловсруулах үйлдвэрийн салбарыг түлхүү хөгжүүлэх шаардлагатайг харуулж байна.


Манай аймгийн ажиллах хүчний оролцооны түвшин 75.5 байгаа нь 2015 оноос 2.6 пунктээр өсчээ.

Судалгааны дүнгээс харахад, ажил хайж багаа иргэдийн тоо 2.5 дахин өсч, ажиллагсдын тоо 49.6 мянгад хүрч өмнөх оноос 3.5 хувиар буюу 1.8 мянган хүнээр буурч, эдийн засгийн идэвхгүй хүн ам 17.7 мянгад хүрсэн нь өнгөрсөн оноос 10.7 хувиар буюу 2128 хүнээр буурсан байна.

**Ашигласан материал, номзүй:**

1. Хөдөлмөр эрхлэлт,ажиллах хүчний үзүүлэлтийг тооцох аргачлал, түүнийг ашиглах гарын авлага- 2015
2. Ажиллах хүчний судалгааны үндсэн тайлан 2011-2015
3. Хүн амын статистикийн үндсэн үзүүлэлт тооцох аргачлал-2013
4. Аймгийн 2016 оны жилийн эцсийн нийгэм,эдийн засгийн танилцуулга
5. Монгол улсын статистикийн эмхэтгэл-2015
6. [www.1212.mn](http://www.1212.mn)

Хүн амын хөдөлмөр эрхлэлтийн бүтэц



Хянасан: Хэлтсийн дарга О.Түмэнжаргал

Танилцуулга бэлтгэсэн: Мэргэжилтэн Э.Өүлэн